

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2024/198/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Мөрөн сум 2024 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn Аудитор: Г.Ичинхорлоо Утас:88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com Аудитор Ц.Мөнхтуяа Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.26 № 01/158
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААН-ҮҮР
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
А.РАДНААБАЗАР ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаан-Үүр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх үндсэн хөрөнгийн дүн өмнөх оноос 130,699.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Аудитын гол асуудал

Аудитаар зардлыг зориулалт, арга хэмжээний дагуу зарцуулаагүй, авлага, өр төлбөр үүсгэсэн, байгууллагын газрын хэмжээг зөрүүтэй бүртгэсэн нийт 8,803.3 мянган төгрөгийн зөрчлийг илрүүлж, 2,000.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 6,803.3 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Цагаан-Үүр сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд “Үнэлгээний үр дүнд суурилан сургуулийн менежментийг сайжруулж, сургалтын чанар, суралцагчийн хөгжилд ахиц гаргана.” зорилгын хүрээнд 9 зорилт дэвшүүлж, 95.0 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

5724040244

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	336,001,288.46	463,365,754.54
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	505,192.66	99,846,754.26
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	505,192.66	99,846,754.26
31210	Төгрөг	505,192.66	99,846,754.26
31211	Төрийн сангийн харилцах	505,192.66	99,846,754.26
33	АВЛАГА	13,725,904.21	1,477,461.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	15,892.00	1,477,461.00
33500	Бусад авлага	13,710,012.21	-
33510	Байгууллагаас авах авлага	13,710,012.21	-
35	БАРАА МАТЕРИАЛ	321,770,191.59	362,041,539.28
35100	Түүхий эд материал	17,705,350.00	18,183,070.00
35110	Тусгай зориулалттай материал	16,804,350.00	16,804,350.00
35130	Эм боох материал	901,000.00	1,378,720.00
35400	Хангамжийн материал	304,064,841.59	343,858,469.28
35410	Бичиг хэргийн материал	2,006,600.00	1,380,100.00
35420	Аж ахуйн материал	2,671,000.00	2,671,000.00
35440	Түлш, шатах тослох материал	40,039,320.15	54,956,250.14
35450	Барилгын засварын материал	769,100.00	769,100.00
35460	Хүнсний материал	22,211,038.11	34,347,225.11
35470	Бусад хангамжийн материал	236,367,783.33	249,734,794.03
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	587,930,964.79	718,630,652.28
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	587,930,964.79	718,630,652.28
39200	Биет хөрөнгө	510,007,964.75	641,647,652.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	321,395,661.33	351,395,213.33
39202	Хуримтлагдсан элэгдэл	-72,626,344.70	-91,379,457.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,800,000.00	29,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-17,797,222.27	-22,763,888.95
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	366,924,210.20	537,642,010.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-201,104,567.99	-243,720,255.23
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	96,214,957.35	96,214,957.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	-72,863,803.07	-76,217,361.31
39214	Бусад үндсэн хөрөнгө	59,491,382.06	60,881,382.06
39215	Хуримтлагдсан элэгдэл	-43,359,400.18	-46,488,229.81
39217	Ном	43,933,092.02	46,283,281.72
39300	Биет бус хөрөнгө	77,923,000.04	76,983,000.08
39301	Программ хангамж	5,737,000.00	5,737,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,976,999.96	-2,916,999.92
39303	Бусад биет бус хөрөнгө	74,163,000.00	74,163,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	923,932,253.25	1,181,996,406.82
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	224,080.00	87,954,782.95
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	224,080.00	27,748,576.95
41200	Богино хугацаат зээлийн өглөг	-	24,790,794.00
41210	Төгрөг	-	24,790,794.00
41211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	-	24,790,794.00
41300	Өглөг	224,080.00	2,957,782.95
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	224,080.00	1,417,782.95
41360	Бусад өглөг	-	1,540,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,540,000.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	60,206,206.00
42200	Урт хугацаат зээл	-	60,206,206.00
42210	Төгрөг	-	60,206,206.00
42211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	-	60,206,206.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	923,708,173.25	1,094,041,623.87
51	Засгийн газрын хувь оролцоо	923,708,173.25	1,094,041,623.87

51100	Засгийн газрын оруулсан капитал	450,514,427.06	450,514,427.06
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	450,514,427.06	450,514,427.06
51200	Хуримтлагдсан үр дүн	222,479,512.08	392,812,962.70
51210	Өмнөх үеийн үр дүн	171,742,689.92	222,479,512.08
51220	Тайлант үеийн үр дүн	50,736,822.16	170,333,450.62
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	250,714,234.11	250,714,234.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	923,932,253.25	1,181,996,406.82

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,454,745,788.00	1,816,145,052.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,425,288.00	86,014,852.40
120	Нийтлэг татварын бус орлого	59,425,288.00	86,014,852.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,970,200.00	2,245,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,970,200.00	2,175,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	70,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	43,897,191.00	70,402,741.70
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	13,557,897.00	13,367,010.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,395,320,500.00	1,730,130,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,223,266,900.00	1,613,332,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,223,266,900.00	1,613,332,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	327,200.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	327,200.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	171,726,400.00	116,797,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	171,726,400.00	116,797,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,404,008,965.84	1,645,811,601.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,404,008,965.84	1,645,811,601.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,322,980,515.84	1,587,467,632.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	913,046,270.34	1,115,100,685.65
210101	Үндсэн цалин	621,023,749.05	778,906,759.55
210102	Нэмэгдэл	241,921,037.20	289,995,209.10
210104	Урамшуулал	50,101,484.09	46,198,717.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,772,302.00	139,906,433.75
210201	Тэтгэврийн даатгал	77,336,273.89	96,161,738.62
210202	Тэтгэмжийн даатгал	9,143,672.93	11,212,110.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,314,938.32	8,881,688.41
210204	Ажилгүйдлийн даатгал	1,812,462.33	2,155,878.98
210205	Эрүүл мэндийн даатгал	18,164,954.53	21,495,017.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,536,096.79	88,930,165.17
210301	Гэрэл, цахилгаан	26,675,466.79	34,297,095.16
210302	Түлш, халаалт	54,860,680.00	54,483,070.01
210303	Цэвэр, бохир ус	1,999,950.00	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,587,450.00	24,332,501.00
210401	Бичиг хэрэг	412,800.00	2,877,200.00
210402	Тээвэр, шатахуун	13,503,150.00	20,364,801.00
210404	Ном, хэвлэл	327,200.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,344,300.00	1,090,500.00
2105	Нормативт зардал	95,909,200.00	100,833,944.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	816,400.00	-
210502	Хоол, хүнс	95,092,800.00	100,833,944.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,352,800.00	12,000,000.00

210604	Урсгал засвар	7,352,800.00	12,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,900,200.00	10,530,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,900,200.00	2,175,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	8,355,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,876,196.71	95,833,803.21
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,441,300.00	9,408,599.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,723,000.00	12,667,350.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	60,711,896.71	73,757,854.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	81,028,450.00	58,343,969.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	74,849,450.00	58,343,969.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	64,336,450.00	58,343,969.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,513,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,179,000.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,179,000.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	50,736,822.16	170,333,450.62
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	50,736,822.16	170,333,450.62

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,397,290,700.00	1,732,375,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,970,200.00	2,245,100.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,970,200.00	2,245,100.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,970,200.00	2,245,100.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,970,200.00	2,245,100.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	70,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,395,320,500.00	1,730,130,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,223,266,900.00	1,613,332,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,223,266,900.00	1,613,332,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	327,200.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	327,200.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	171,726,400.00	116,797,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	171,726,400.00	116,797,300.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,367,499,507.34	1,598,078,538.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,367,499,507.34	1,598,078,538.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,283,493,507.34	1,527,336,038.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	913,046,270.34	1,116,562,254.65
210101	Үндсэн цалин	621,050,463.80	749,271,935.65
210102	Нэмэгдэл	241,870,733.52	318,473,117.00
210104	Урамшуулал	50,125,073.02	48,817,202.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,772,302.00	139,906,433.75
210201	Тэтгэврийн даатгал	77,349,538.31	93,684,233.75
210202	Тэтгэмжийн даатгал	9,099,869.91	11,664,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,280,096.14	9,331,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,842,956.44	2,332,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,199,841.20	22,893,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,297,400.00	104,797,300.00
210301	Гэрэл, цахилгаан	28,297,400.00	31,297,300.00
210302	Түлш, халаалт	73,000,000.00	70,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.00	3,500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	327,200.00	-

210404	Ном, хэвлэл	327,200.00	-
2105	Нормативт зардал	85,334,300.00	100,571,600.00
210502	Хоол, хүнс	85,334,300.00	100,571,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,000,000.00	12,000,000.00
210604	Урсгал засвар	6,000,000.00	12,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,987,000.00	10,555,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,900,200.00	2,175,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,086,800.00	8,380,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,729,035.00	42,943,350.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,598,835.00	30,276,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,130,200.00	12,667,350.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	84,006,000.00	70,742,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	77,827,000.00	70,742,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	67,314,000.00	70,742,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,513,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,179,000.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,179,000.00	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	29,791,192.66	134,296,761.60
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	29,286,000.00	34,955,200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	29,286,000.00	34,955,200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	29,286,000.00	34,955,200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	29,286,000.00	34,955,200.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-29,286,000.00	-34,955,200.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	505,192.66	99,341,561.60
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	505,192.66
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	505,192.66	99,846,754.26

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	450,514,427.06	250,714,234.11	171,742,689.92	872,971,351.09
Тайлант үеийн үр дүн	-	-	50,736,822.16	50,736,822.16
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	450,514,427.06	250,714,234.11	222,479,512.08	923,708,173.25
2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	450,514,427.06	250,714,234.11	222,479,512.08	923,708,173.25
Тайлант үеийн үр дүн	-	-	170,333,450.62	170,333,450.62
2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	450,514,427.06	250,714,234.11	392,812,962.70	1,094,041,623.87

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Улсын төсвийн гүйцэтгэл:

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,616,083,400.00	1,516,201,438.40	93.82	99,881,961.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,616,083,400.00	1,516,201,438.40	93.82	99,881,961.60

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,537,637,100.00	1,445,458,938.40	94.01	92,178,161.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,198,676,900.00	1,116,562,254.65	93.15	82,114,645.35
210101	Үндсэн цалин	828,095,800.00	749,271,935.65	90.48	78,823,864.35
210102	Нэмэгдэл	315,540,500.00	318,473,117.00	100.93	-2,932,617.00
210104	Урамшуулал	55,040,600.00	48,817,202.00	88.69	6,223,398.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,834,900.00	139,906,433.75	93.37	9,928,466.25
210201	Тэтгэврийн даатгал	101,888,000.00	93,684,233.75	91.95	8,203,766.25
210202	Тэтгэмжийн даатгал	11,986,800.00	11,664,500.00	97.31	322,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,589,300.00	9,331,400.00	97.31	257,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,397,300.00	2,332,800.00	97.31	64,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	23,973,500.00	22,893,500.00	95.50	1,080,000.00
2105	Нормативт зардал	100,571,600.00	100,571,600.00	100.00	-
210502	Хоол, хүнс	100,571,600.00	100,571,600.00	100.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,620,000.00	10,555,100.00	99.39	64,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,175,100.00	2,175,100.00	100.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,444,900.00	8,380,000.00	99.23	64,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	77,933,700.00	77,863,550.00	99.91	70,150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65,266,300.00	65,196,200.00	99.89	70,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,667,400.00	12,667,350.00	100.00	50.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,446,300.00	70,742,500.00	90.18	7,703,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	78,446,300.00	70,742,500.00	90.18	7,703,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	78,446,300.00	70,742,500.00	90.18	7,703,800.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,616,083,400.00	1,615,543,000.00	99.97	540,400.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,613,332,900.00	1,613,332,900.00	100.00	-
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,613,332,900.00	1,613,332,900.00	100.00	-
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,750,500.00	2,210,100.00	80.35	540,400.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,175,100.00	2,175,100.00	100.00	-
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	35,000.00	50.00	35,000.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	505,400.00	-	0.00	505,400.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	505,192.66		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	99,846,754.26		

Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	122,179,600.00	116,797,300.00	95.59	5,382,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	122,179,600.00	116,797,300.00	95.59	5,382,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	122,179,600.00	116,797,300.00	95.59	5,382,300.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	108,179,600.00	104,797,300.00	96.87	3,382,300.00
210301	Гэрэл, цахилгаан	34,679,600.00	31,297,300.00	90.25	3,382,300.00
210302	Түлш, халаалт	70,000,000.00	70,000,000.00	100.00	-
210303	Цэвэр, бохир ус	3,500,000.00	3,500,000.00	100.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,000,000.00	12,000,000.00	85.71	2,000,000.00
210604	Урсгал засвар	14,000,000.00	12,000,000.00	85.71	2,000,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	122,179,600.00	116,797,300.00	95.59	5,382,300.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	105,882,300.00	116,797,300.00	110.31	- 10,915,000.00
320001	Орон нутгийн төсвөөс	105,882,300.00	116,797,300.00	110.31	- 10,915,000.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	16,297,300.00	-	-	16,297,300.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	16,297,300.00	-	-	16,297,300.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 560,188.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлсэн. Үүнд:

- Санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 8,803.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2,000.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 6,803.3 мянган төгрөгийн 4 зөвлөмжийг хүргүүлсэн.
- Нийцлийн аудитад хамааралтай 18,441.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэв.

Санхүүгийн тайлагналтай холбоотой 8,803.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшнээс 13,660.8 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

3.1 Төлбөрийн акт

Мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах чиг үүрэгтэйгээр ажилладаг аймгийн Хөвсгөл аймгийн БШУГ-ын мэргэжилтэн Баасандоржийн дансанд багшийн хөгжлийн зардлаас 2,000.0 мянган төгрөгийн сургалтын төлбөр шилжүүлсэн байгаа нь Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.5-д “Аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс харьяа нутаг дэвсгэртээ дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах;”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;” заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь, бүрэн байршуулах өмнөх оны аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 18,441.8 мянган төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй байгаа нь “Шилэн дансны тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;” заалт, 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн

авагчийн нэр;” заалт болон “ нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байх тул албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус сургуулийн үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 22 нэр төрлийн 46,505.2 мянган төгрөгийн 259 хөрөнгө бүртгэлтэй байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн параграф 67, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;” заалт болон ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар бүлгийн 7.1 заалттай тус тус нийцээгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ОНӨГ-т хүргүүлэн шийдвэрлүүлж, үр дүнг нягтлан бодох бүртгэлд тусгах

2. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сургуулийн цахим хэрэглээний зардлаас нягтлан бодогч, нярав 540.0 мянган төгрөгийн дата авсан, багшийн мэргэжил дээшлүүлэх зардлаас бичиг хэргийн ажилтны сургалтын төлбөр 80.0 мянган төгрөг төлсөн, танхимаас гадуурх сургалтын зардлаас багш сурагчдын уралдаан тэмцээнд явсан шатахууны зардал 1,689.0 мянган төгрөг төлсөн, эрүүл мэндийг дэмжих хөтөлбөрөөс 263.5 мянган төгрөгийн эм худалдаж авсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;” заалт, БШУС-ын 2019 оны А/170 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”, хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”, Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал” – ын хавсралтад заасан зориулалт, арга хэмжээтэй нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг батлагдсан зориулалт, арга хэмжээний дагуу, холбогдох хууль, журам, зааварт нийцүүлэн зарцуулж байх.

3. Өр, төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус сургууль нь тайлант жилд гэрэл цахилгаан, тоног төхөөрөмж худалдаж авсантай холбоотой 2,957.8 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." заалттай нийцэхгүй, “эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн гүйцэтгэлд сар бүр дүн шинжилгээ хийж, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, үүссэн өр төлбөрийг барагдуулах.

4. Газрын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус сургуулийн эзэмшилд боловсролын байгууллагын зориулалттай 35,695 м.кв, жимс жимсгэнийн усалгаатай тариалангийн зориулалттай 1,773 м.кв, нийт 37,468 м.кв талбай бүхий газар гэрчилгээ, кадастрын зургаар баталгаажсан боловч нягтлан бодох бүртгэлд 74,163.0 мянган төгрөгийн 1 газраар газрын хэмжээ тодорхойгүй бүртгэсэн байна. Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоол “Газрын үнэлгээний тойрог, зэрэглэл (бүс), суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай “ 6-р хавсралтаар сумын төвийн худалдаа, бүх төрлийн үйлчилгээний зориулалт бүхий газрын үнэлгээгээр тооцоход 773.0 мянган төгрөгөөр дутуу үнэлсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлд газрыг үнэн зөвөөр бүртгэж, залруулах.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
БШУГ-ын мэргэжилтэн өөрийн чиг үүргийн дагуу хийсэн сургалтад төсвөөс төлбөр авсан.	1	2,000.0	1	2,000.0				
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө нягтлан бодох бүртгэлд бүртгэлтэй байна.	1	-					1	-
Зардлын зориулалт, арга хэмжээнд нийцүүлж зарцуулаагүй байна.	1	2,572.5					1	2,572.5
Өр төлбөр үүсгэсэн.	1	2,957.8					1	2,957.8
Газрыг зөрүүтэй дүнгээр бүртгэсэн.	1	773.0					1	773.0
Дүн	5	8,303.3	1	2,000.0			4	6,303.3

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 7 мэдээлэл оруулаагүй, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй	1	18,441.8			1	18,441.8		
Дүн	1	18,441.8			1	18,441.8		

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2024 оны 02 сарын 26 өдөр

№ 39/АЭЭТ 0439/20А-2024/
198/АА-СМА-ИИС

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.
Үүнд:

Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих болон боловсролын стандарт сургалтын хөтөлбөр арга хэмжээний батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргахдаа мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн Б.Баасандоржтой гэрээ байгуулан, сургалт хийлгэж 2,000,000/хоёр сая / төгрөгийн төлбөр төлсөн байна.

Энэ нь Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.5-д "Аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс харьяа нутаг дэвсгэртээ дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, багш, ажилтны мэргэжлийн хөгжлийг хангах, зөвлөн туслах", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

- Мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах чиг үүрэгтэй албан хаагчид гэрээгээр төлсөн төлбөр 2,000,000/хоёр сая/ төгрөгийг Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтэн Б.Баасандоржоос гаргуулж Хөвсгөл аймгийн Төрийн сан дахь 100170000955/Хө.Бусад нэр заагдаагүй орлого/ тоот дансанд төвлөрүүлэх;
- Актын биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т нотлох баримтын хамт ирүүлэхийг Цагаан-Үүр сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал А.Раднаабазар, нягтлан бодогч Т.Төмөржаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
"ИХЭР МӨРӨН АУДИТ" ХХК
ЗАХИРАЛ

А.ЭРДЭНЭБААТАР

Б.МЯДАГМАА



¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот

6724000128



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 26 өдөр

№ 26/А.2270439/ХАА-2024/
198/ХА-С/И А-11213

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цагаан-Үүр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 18,441,800 (арван найман сая дөрвөн зуун дөчин нэгэн мянга найман зуу)-н төгрөгийн 2 мэдээлэл мэдээлээгүй байна.

2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4. "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т "Аудитаар илэрсэн алдаа зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй", 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

- Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулж, ил тод байдлыг ханган, илэрсэн зөрчлийг арилгаж биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 20-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;
- Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Тосонцэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал А.Раднаабазар, нягтлан бодогч Т.Төмөржаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
"ИХЭР МӨРӨН АУДИТ" ХХК
ЗАХИРАЛ

А.ЭРДЭНЭБААТАР

Б.МЯДАГМАА

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот

6724030090